

## ГОФРА ХООЛОЙНЫ ХУДАЛДАН АВАЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Цахилгаан дамжуулагч сүвлэх атираат уян хоолой нь УБЦТС ТӨХК-ийн ТШТ: ЕШН “Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл” техникийн шаардлагын тодорхойлолтыг хангахын зэрэгцээ төрөл маяг тус бүрт тавигдах ГОСТ 9389, ГОСТ 50827-95, ГОСТ 14254, ГОСТ 15150 стандартын шаардлагад нийцсэн байх ёстой.

Санал болгож буй бүтээгдэхүүний бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт болон каталогийг ирүүлэх ба загвар ирүүлнэ.

### 1.ГОФРА ХООЛОЙД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГУУД

Цахилгаан дамжуулагч сүвлэх атираат уян хоолой нь УБЦТС ТӨХК-ийн ТШТ: ЕШН “Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл” техникийн шаардлагын тодорхойлолтыг хангахын зэрэгцээ төрөл маяг тус бүрт тавигдах ГОСТ 9389, ГОСТ 50827-95, ГОСТ 14254, ГОСТ 15150 стандартын шаардлагад нийцсэн байх ёстой. Үйлдвэрлэгчийн чанарын шаардлагын хангасан гэрчилгээ ирүүлнэ.

Уян хоолойн материалын (полиамид) талаар баталгаат лабораторын шинжилгээний бичиг байх шаардлагатай.



- Цахилгаан дамжуулах утас сүвлэх зориулалт бүхий уян хатан, хөнгөн байх
- Температурын өөрчлөлтөнд тэсвэртэй байх, хугардаггүй байх
- Дулаан дамжуулалт бага
- Хэт ягаан туяаны үйлчлэлд тэсвэртэй байх
- Зэврэлт болон химийн бодисонд тэсвэртэй байх
- Гал дэмждэггүй
- Хар өнгөтэй
- Гадаа суурилуулах зориулалтын байх

Үзүүлэлтүүд	Шаардлага
Атираат хоолойны хийц	ТУ 2247-001-97341529-2008
Материал	Нягтруулсан уян полиамид ПА
Дотор диаметр	22, 32, 50, 100 мм-аас багагүй

Бат бэх	20°С –ийн үед 5 см-т 350 Н-аас багагүй
Ашиглалтын температур	-40° С аас +45° С
Угсралт хийх үеийн температур	-40° С аас +90° С
Хамгаалалтын түвшин хүрээлэн байгаа орчны үйлчлэлд	IP55 УХЛ1 ГОСТ 15150
360 градус мурийлгах үеийн хамгийн бага радиус	мурийлгах радиус нь хоолойны гадна диаметрээс 3 дахин тэнцүү
Галын эсэргүүцэл	ГОСТ Р 50827 (МЭК 670-89)-ын дагуу
Өнгө	Хар
Хадгалах хугацаа	2 жилээс багагүй
Ашиглалтын хугацаа	10 жилээс багагүй

### Ашиглалтын нөхцөл

Ашиглалтын нөхцөл нь “ТШТ: ЕШН Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл”-ийн “24. Орчны нөхцөл”-д шаардлагад нийцсэн байх ёстой.

### Тээвэрлэлт ба хадгалалт сав баглаа боодол

Нийлүүлэгдэх бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт, сав баглаа боодол нь ГОСТ 18690-82 “Кабель, дамжуулагч, утас ба кабелийн дагалдах хэрэгсэл. Барааны тэмдэглэгээ, сав баглаа, боодол тээвэрлэлт ба хадгалалт” стандартын шаардлагуудыг хангасан байх ёстой.

Дээрх тоноглол нь “ТШТ: ЕШН Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл”-ийн суурь норматив баримт бичгүүд дээр заасан бүх заалтыг мөрдсөн байх ёстой.